



## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2018 оны 02 дугаар сарын 05

№ 01/05 дугаар 2018/121/СТА-ТЧЗ Мандалговь хот

Г

### Төлбөр барагдуулах тухай

Г

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн албаны даргад Засаг даргын орлогчийн ажлын чиг үүрэгт заагдсан ОНХС-гийн ажлыг давхар хавсруулан, ажил хавсарсны нэмэгдэл **1,554,706.00** /Нэг сая таван зуун тавин дөрвөн мянга долоон зуун зургаан/ төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3 /батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолын 2.а-д /Бүх шатны төсөв захирагч наарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтрзуулах зэргээр орон тоо, цалин хөлс, урсгал зардлыг бууруулах, батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх эрхийг олгох/, мөн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 5-ны өдрийн “Ажил үүргийн хуваарь батлах” тухай А/03 дугаар тушаалын хавсралтад /Засаг даргын орлогч ... ОНХС-гийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэдээ тайланг гаргаж, дээд шатны байгууллагад өгөх, олон нийтэд мэдээлэх, програмд шивж оруулах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомжс, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжсуулэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-д /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**


1. Давхардуулан олгосон **1,554,706.00** /Нэг сая таван зуун тавин дөрвөн мянга долоон зуун зургаан/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь

аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд 2018 оны 04 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Эрдэнэбаатар, нягтлан бодогч А.Соёл-Эрдэнэ нарт хариуцуулав.

### АКТЫГ

#### ТОГТООСОН<sup>1</sup>:

АУДИТОР:  ТОЮУН-ЭРДЭНЭ

4817144213  
ЗЮА0039 9033475

#### ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА:  Д.ЭРДЭНЭБААТАР

НЯГТЛАН БОДОГЧ:  А.СОЁЛ-ЭРДЭНЭ

9.1.2018 09:33:129

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гарасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.